

ялтны хөдөлмөрийн нөхцлийг өөрчлөх урамшуулал нь практикт хэрэгждэггүй, хэрэглэх зааврыг гаргаж өгөөгүй

2. Ялтанд олгох чөлөөний асуудал. (Хорих ялын хугацаа дуусаж байгаа, хорих ангийн дэглэм журмыг чанд мөрдөж, зөрчил дутагдал гаргаж байгаагүй ялтныг урамшуулах, нийгэмшүүлэх зорилгоор тодорхой хугацаагаар чөлөө олгож байх.)
3. Хорих ангийн дэглэм журмыг чанд сахиж, нийгэм иргэдэд учруулсан гэмт үйлдэлээ ухамсарлаж гэмшиж, үүнийгээ ял эдлэх хугацаандаа зан байдлаараа харуулсан, өөрийгөө хөгжүүлж сурч боловсорч байгаа ялтнуудад урамшуулал олгох асуудал
4. Тахир тутуу, хөгжлийн бэрхшээлтэй, өвдсөн, жирэмсэн, хүүхдээ асарч байгаа ялтнуудад олгох урамшуулах асуудал
5. Цагдан хорих байранд хоригдож байгаа хоригдогчдод болон хүлээлгэнд байгаа дотоод журмыг чанд мөрдөж, удаан хугацаагаар хоригдож байгаа ялтнуудад урамшуулал үзүүлэх асуудал /Хорих өрөөний нөхцлийг сайжруулах, сайшаалын үнэмлэх олгох гэх мэт/



**Т.ЕРКЕБУЛАН**

*Баян-Өлгий аймгийн  
Шүүхийн шийдвэр  
гүйцэтгэх албаны  
ээлжийн дарга, ахмад*

### **ХОРИХ ЯЛ ЭДЛЭГСЭДЭЭС ТӨЛБӨР ГАРГУУЛАХ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ**

Өнөөгийн нийгэмд хорих ял эдлэгсдээс төлбөр гаргуулах ажиллагаа нь хууль сахиулах байгууллагуудын өмнө тулгамдсан асуудал болоод байна. Хуульд заасан чиг үүргийнхээ хувьд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь эдгээр ажлыг гардан гүйцэтгэж байна. Хорих ял эдлэгсдээс иргэн, байгууллагад учруулсан хохирлыг төлүүлэх, явдал нь гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн эрх, эд хөрөнгийг хамгаалж байгаа асуудал юм. Монголын эртний хууль цаазын эх сурвалжуудад ял шийтгэгдсэн этгээдээс учруулсан хохирлыг нөхөн төлүүлж байсан баримтууд Их засаг хуульд тэмдэглэгдсэн байдаг.

Мөн Түмэдийн Алтан хааны цаазад “хүн алваас гурав жаншиж, тэргүүн есөөр торгож, нэг хүнээр өр босго” мөн хүмүүсийн хэрүүл зодооны завсраар шударга хүн орж алагдвал торгох, занших шийтгэлээс гадна “хүн тэмээ аль нэгээр өр босго” гэж заасан нь гэмт хэргийн улмаас хохирогчийн хохирлыг барагдуулах хэлбэр байжээ гэж дүгнэж болохоор байна.

1992 оны “Монгол Улсын Үндсэн хуулийн 16-зүйлийн 14 дэх хэсэгт зааснаар иргэн нь Монгол улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бус үйл ажиллагааны улмаас учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх” эрхтэй. 19-зүйлд “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг нөхөн сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцана” гэж тус тус<sup>45</sup> заажээ.

ШШГБ нь хорих ялыг эдлүүлэх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, түүний дотор эрх зүйн зөрчлийн улмаас эрх нь зөрчигдсөн этгээдийн эрхийг шүүхийн шийдвэрийн дагуу нөхөн сэргээх, учирсан хохирлыг арилгах чиг үүргээ хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд гүйцэтгэж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуульд зааснаар, гэмт хэрэг үйлдсэний улмаас иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирол, төлбөрийг ялтны хөдөлмөрийн хөлснөөс суутгаж хохирогчид шилжүүлэх гэсэн заалт нь өнөөдрийн нийгэмд учир дутагдалтай байгаа юм.

### Эдгээр ажиллагаанд:

1.Төлбөр төлөгч буюу ялтны эд хөрөнгө байгаа талаар хуульд заасан журмаар мэдээлэл олж авах, түүний мөнгөн хадгаламж болон харилцах данснаас хасалт хийх, эд хөрөнгө болон биед нь үздэг, нэгжлэг хийх, эд хөрөнгийг албадан гаргуулах, баригцаалах, хураах худалдаан борлуулах.

2. Ялтны бусдад өмч хөрөнгөөс төлбөр гаргуулах.

Түүнээс гадна 2007.12.04-ны өдрийн Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Хохирогчийн эрхийн баталгаа” сэдэвт хүний эрхийн үндэсний чуулганыг Ерөнхийлөгчийн тамгийн газар, Хүний эрхийн үндэсний комисс хамтран зохион байгуулж, чуулганаас хохирогчийн эрхийг хангах, хамгаалах, хөхүүлэн дэмжих чиглэлээр зөвлөмж гаргасан нь хохирогчийн эрх зүйн баталгааг хангахад чухал ач холбогдолтой болсон. 5 заалт бүхий зөвлөмжийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад даалгасан.

Уг зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор ШШГБ нь хууль, тогтоомжийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон эрүү, иргэн захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, гэмт хэргийн болон захиргааны хууль бус ажиллагаанаас хохирсон иргэдийн эрхийг хангах, тэдгээрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлөлтийн бодит биелэлтийг нэмэгдүүлэх, төлбөртэй ялтныг хөдөлмөрт хамруулах, гэмт хэрэг үйлдэж бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхэд онцгой анхаарч тодорхой зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна<sup>46</sup>.

Үүнд: Эрүүгийн хэргийн хохирлыг нөхөн төлүүлэх талаар гарсан шүүхийн шийдвэрийн гүйцэтгэл хангалтгүй байгаад анхаарал хандуулж, нэгэнт гарсан шүүхийн шийдвэрийн заавал биелүүлэх,

<sup>45</sup>“Эрх зүйн, албаны мэдээлэл” УБ хот 2008 №4

<sup>46</sup>Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2009.10.02-ны өдрийн 198 дугаар тушаал

хэрэгжилтийг бүрэн хангах талаар тусгайлан хөтөлбөр боловсруулж ажиллаж байна. Эдгээр хөтөлбөрийг хэрэгжүүлж ажилласнаар сүүлийн жилүүдэд хорих ял эдлэгсэдээс төлбөр гаргуулах ажиллагаанд үр дүн гарсан үзүүлэлтүүд гарсаар байна.

Гэмт хэргийн улмаас иргэд байгууллагуудад, энэ төрлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд үр дүнтэй гүйцэтгэх үүднээс хорих ял эдэлж байгаа ялтны хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажлын байраар хангах улмаар хөдөлмөрийн хөлснөөс хохирогчийн хохирлыг аль болох түргэн шуурхай нөхөн төлүүлэх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор 2008-2012 онд “Ялтны гэм хорын хохирол барагдуулалтанд хяналт тавьж ажиллах хөтөлбөр”-ийг ШШГЕГ-ын 2008 оны А/102 тоот тушаалаар батлан гаргаж, хэрэгжилтийг харьяа нэгжүүдэд болон ял эдлүүлж буй ялтнуудад сурталчлах ажлыг тухайн хорих ангиуд дээр зохион байгуулан ажиллаж байна.

#### Уг хөтөлбөрийг хэрэгжүүлснээр:

1. Төлбөртэй ялтныг хугацаанаас өмнө тэнсэн суллахгүй байх.
2. Ялтанг ажлын байраар хангаж, нийгэмд зөв хүн болгон төлөвшүүлэх, тэдэнд мэргэжил олгох,
3. Ялтны ахуйн хангамж, амьдрах орчин сайжруулж, тодорхой орлоготой болгох.
4. Ялтны төлбөрийн мөнгийг хохирогчдод олгох ажиллагааг шуурхай олгож, тодорхойбодлого дэвшүүлэн ажиллаж байна.

Хорих ангид ял эдэлж буй төлбөртэй ялтны судалгааг хорих анги бүрээс сар бүр авч, хохирол барагдуулалтанд хяналт тавьж

ажилласнаар 2013 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 2358 ялтны 152 тэрбум 418 сая 736 мянган төгрөгний төлбөр байгаагаас 483 ялтанд холбогдох 819 сая 739 мянган төгрөгийг дансанд төвлөрүүлэн гэм хорын хохирлыг барагдуулсан байна. Эдгээр дүн судалгаанаас үзэхэд ялтнаас төлбөр гаргуулах ажиллагаа нь 51 хувьтай байгаа нь өмнөх онуудаас өссөн үзүүлэлт гарч байна. ШШГБ нь хорих ангид ял эдэлж байгаа хугацаанд нь хөдөлмөрт татан оролцуулж, гэмт хэрэг үйлдэж бусдад учруулсан хохирлыг барагдуулах ажиллагааг тухайн хорих ангийн онцлогт тохируулан зохион байгуулж байгаа бөгөөд ялтныг ажил хөдөлмөр эрхлүүлж бусдад учруулсан нөхөн төлүүлэх, нийгмийн амьдралд эргэн ороход нь дэмжих, тэдгээрийг нийгэмшүүлэх тодорхой хөтөлбөрийн дагуу сургалт явуулж байна<sup>47</sup>.

Улсын төвлөрсөн төсөв болон байгууллагын дотоод орлогоор санхүүжүүлэн хорих анги, шийдвэр гүйцэтгэх албадуудад бүтэн байгуулалтын ажил сүүлийн жилүүдэд эрчимтэй хийгдэж байгаатай холбоотойгоор ялтнуудын хөдөлмөр эрхлэлт нь эрс нэмэгдэж төлбөртэй ялтнуудын хөдөлмөрийн хөлснөөс учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагаа эрчимжиж байна. Ялтнуудыг ажлын байраар хангаж ажиллуулснаар нэг талдаа ялтнуудад хөдөлмөрийн дадал эзэмшиж, нөгөө талдаа учруулсан хохирлоо нөхөн төлөх бололцоо бүрдэж байна.

Ялтныг хөдөлмөрлүүлэх, тэдгээрт мэргэжлийн дадлага олгох, нийгэмшүүлэх үүднээс вакум цонхны үйлдвэрлэл, зам

<sup>47</sup>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2013 оны хагас жилийн хохирол барагдуулалтын мэдээ

талбайн тохижуулалтын материалын үйлдвэрлэл, шохойн үйлдвэрлэл, алт мөнгөн эдлэл дархан, мужаан, уран зураг, зөөлөн оёдлын үйлдвэрлэл, ногоон боржин чулуу, улаан тоосгоны болон чулуун нүүрсний хөрс хуулалтын ажлыг гүйцэтгэж байгаа нь ялтнууд хөдөлмөр эрхлэн орлоготой болсноор учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх хөшүүрэг болж байна.

Хорих ангид ял эдэлж байгаа ялтныг ажлын байраар хангаж, нийгмийн амьдралд эргэн ороход нь дэмжих зорилгоор Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд сургалт явуулж мэргэшүүлэх, мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээ олгох ажиллагааг зохион байгуулаж улмаар гэмт хэрэг үйлдэж бусдад учруулсан хохирлоо нөхөн төлүүлэх, хорих ангийн үйлдвэрлэлийг хөгжүүлж ажилсанаар одоогийн байдлаар 2000 гаруй ялтныг ажлын байраар хангаж ажиллаж байгаа нь нийт ялтнуудын 40 гаруй хувийг эзэлж байгаа юм.

Гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн ялтан эргээд нийгэмд ажиллаж, амьдрахад учирч болох хүндрэлийг багасгах зорилгоор хорих ангид ял эдлэгсэдийг нийгэмд буцаан гаргах, тэднийг дасан зохицох, мэргэжил, боловсрол олгох асуудалд онцгой анхаарч, тэдгээрийн дунд явуулахнийгмийн ажлыг боловсронгуй болгох үүднээс Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийг ашиглалтанд оруулж ажиллаж байна.

Хорих ял эдлэгсэдээс төлбөр гаргуулах ажиллагааг боловсронгуй болгох, эрх зүйн орчныг сайжруулахад эрдэмтэн, мэргэд, судлаачдын санал бодлыг сонсож дэлхийн нийтийн чиг хандлагад хүргэх зайлшгүй шаардлага гарч байна. Төлбөр гаргуулах ажиллагааг ганцхан шүүхийн

шийдвэр гүйцэтгэх байгууллага ажиллах биш хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүх, прокурорын байгууллагын хамтын ажиллагаа чухал юм. Өөрөөр хэлбэл хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны шатнаас сэжигтэн, яллагдагч, эд хөрөнгийг хураах, битүүжлэх ажиллагааг орхигдуулахгүйгээр явуулах нь тухайн этгээдийн гэм буруутай нь тогтоогдсон тохиолдолд нийгэмд учруулсан хохирлоо нөхөн төлүүлэх ажиллагаа нь хурдан шуурхай явуулах боломж бүрдэнэ. Нөгөө талдаа хураагдсан, битүүмжлэгдсэн эд хөрөнгүүдийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах, нуух, үрэгдүүлэхээс хамгаалж байдаг онцлогтой.

Мөн ялтны зан байдлыг төлөвшүүлэх, мэргэжил, боловсрол эзэмшүүлэн хөдөлмөрт татан оролцуулах, хохирлыг нөхөн төлүүлэх чадвар эзэмшүүлэх, хорих ангиас суллагдсаны дараа нийгмийн амьдралд байр сууриа олж амьдрахад нь дэмжлэх үзүүлэх зорилгоор “Ялтны нийгэмшүүлэх ажлын хөтөлбөр”-ийг эрчимтэй хэрэгжүүлсэнээр тодорхой үр дүнд хүрч ажилласан үзүүлэлттэй байна. Цаашид ялтны нийгэм, иргэдэд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагааг төгөлдөржүүлэхэд дараах саналуудыг дэвшүүлж байна

**Үүнд:** 1. Хоригдлын хөдөлмөр эрхлэлттэй холбоотой тулгамдсан асуудлыг нэн илрүүлж, дэлхийн нийтийн чиг хандлагад хүргэх, томоохон бодлого боловсруулан цогц арга хэмжээг хэрэгжүүлэх,

2. Гэрээгээр хамтран ажиллах иргэн, аж ахуйн нэгжийн тоог нэмэгдүүлж, хорих